



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 23 өдөр

Дугаар А/13

Өвт

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бат-Өлзий сумын зорилтот өрх, иргэнд хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээг хүргэх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Б.Янжиндулам-Байгаль орчны хяналтын улсын байцаагч

Гишүүд: Д.Бадамдулам-Санхүү албаны дарга

Г.Доржханд-Төрийн захиргааны ажил хариуцсан мэргэжилтэн

Ж.Хүнийхүн- Иргэний төлөөлөл


Нарийн бичгийн дарга: Н.Долгормаа-Нийгмийн ажилтанх

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан, мэдэгдэл, гэрээний төслийг өргөн мэдүүлэхийг Үнэлгээний хороо (Б.Янжиндулам)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгийг хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж, Архив, бичиг хэргийн эрхлэгчид хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Н.Долгормаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

М.ЖАМЪЯНШАРАВ



C:\My Doc A-4 zahiramj /Zasag darga/

051011025